

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-016759
ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ ДАХЬ БУРХАН ДЭЛ
АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар 2023 он

ОРШИЛ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дэвсгэрт Мандал ресурс ХХК нь МV-016759 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бурхан дэлийн алтны үндсэн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) “Эм Эс Эл Ти” ХХК боловсруулсан бөгөөд нь 2022 оны 09 сарын 15-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан болно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Шүрэн завъяа ХХК 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 13/5633 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны байгаль орчны стратеги үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, уул уурхай, хүнд үйлдвэрийн төслийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр тайланг хэлэлцүүлэн батлуулсан байдаг ба 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дээрх байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн боловсруулсан байдаг.

2023 оны байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ихэнх ажил хийгдээгүй бөгөөд учир нь ордыг ашиглах үйл ажиллагааны бэлтгэл ажил болох ажилдчын байр, хотхон барих, хүдэр боловсруулах үйлдвэрийн угсарлт, барилгын ажил хийгдэж дуусаагүй тул ил уурхайн ажил хийгдээгүй болно. Тиймээс ил уурхайн олборлолтын ажил явагдаагүй тул техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй болно. Харин бүтээн байгуулалтай холбоотой барилга байгууламж болон замтай холбоотой тоосжилтоос хамаалах усалгааг тогтмол хийсэн бол ажилчдын байр хотхонд 2023 оны 10-р сард Газрын төлөв байдлын хянан баталгаа хийлгэн 40,000м² бүхий газарт хөрс, ус, ургамлын төлөв байдлыг тодорхойлуулсан. Хотхон баригдаж дууссаны дараа 2023/12-р сард дараагийн Газрын төлөв байдлын хянан баталгаа хийлгэж “Газрын төлөв байдал, чанарт өөрчлөлт ороогүй, тохижилт сайтай” гэсэн дүгнэлт гарсан болно. Мөн хүдэр баяжуулах үйлдвэрийн барилга /177,598м²/, Шохойн үйлдвэр /700м²/, Тэсрэх материалын агуулах /5,005м²/-ын газарт эхний байдлын Газрын төлөв байдлын хянан баталгаа хийлгэсэн. Барилгын ажил дууссаны дараа дахин дүгнэлт гаргуулахаар байгаа төлөвлөөд байна. Өмнөговь аймгын Мандал-Овоо сумын засаг даргын тамгын газартай 2023/01/02-ны өдөр гэрээ байгуулж хог хаягдлын түр цэг байгуулах зөвшөөрөл авсаны дагуу хог хаягдалыг ангилан ялгаж, зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй, таарсан тагтай, цоорч гэмтхээргүй, салхиар тарахгүй, шингэн нэвчихгүй байхаар байршуулсан. Зориулалтын дагуух тээврийн хэрэгслээр маршрутын дагуу заасан цэгт хүргэж, нутаг дэвсгэрийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Хог хаягдлыг тайлан мэдээг тогтмол ЗДТГ-т хүргүүлж ажиллаж байна. Мөн 2023 онд Өмнөговь аймгын Мандал-Овоо сумын засаг даргын тамгын газартай 2023/08/30-ны өдөр гэрээ байгуулж ажилчдын хотхоноос гарсан бохир усыг Мандал-Овоо суманд орших бохирын талбайд асгаж, холбогдох төлбөрийг 1тн тутмаар тооцон төлж байна. Өмнөговь аймгын Мандал-Овоо сумын засаг даргын тамгын газартай 2023/07/28-ны өдөр Унд, ахуйн зориулалтаар 11,808м³ хүртэлх усыг Усны тухай хуулийн дагуу ашиглах гэрээ байгуулсан. Усны нийт 4 удаагийн шинжилгээг 5, 10, 11, 12-р саруудад өгсөн. Байгаль хамгаалах болон нөхөн сэргээх үйл

ажиллагаа бүхий “Амин хэлхээ байгаль сан” ТББ-тай гэрээ хийж эхний ээлжинд 450 ш модны суулгац худалдан авч тарихаар хүлээгдэж байгаа бол Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгын Мандал-Овоо сумын мод үржүүлгийн газарт 2,300 орчим мод суулгац тарих гэрээ байгуулсан ба дараа он буюу 2024 онд тарихаар төлөвлөөд байна. Мөн эхний туршилтын байдлаар 30 модны суулгац аван 10 модыг Мандал-Овоо суманд 20 модыг ажилчдын хотхонд эхний байдлаар суулган тарьсан болно.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	“Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага	<ul style="list-style-type: none">- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Мандал ресурс” ХХК- Улсын бүртгэлийн дугаар: 9011405030- Регистрийн дугаар: 5699134- Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Авзага трейд оффис 3 давхар, 301 тоот.- Утас: 9999-3639


1.1.1 Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Бурхан дэлийн алтны ороген орд нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Мандал овоо сумын Баянхошуу багийн нутаг дэвсгэрт сумын төвөөс баруун урагшаа 40км – т орших Бурхан дэлийн уулын өвөрт, Улаанбаатар хотоос баруун урагш 500км – т аймгийн төв Даланзадгад хотоос баруун хойш 120км – т байрлана.

Уг орд нь газарзүйн байршлын хувьд говийн бүсд, Ханын хэцийн тогтоцийн баруун хэсэгт, Онги голын төгсгөлөөс 40 орчим км зайд байрлаж байна. Талбайн хэмжээ нь 450.73 га бөгөөд талбайн солбицолын цэгүүдийг Хүснэгт 1-1-д, байршлыг Зураг 1-1-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 1-1. Төслийн талбайн солбицол

Цэг ¹	Х	Ү	Талбайн хэмжээ
1	104° 5' 21.1''	44° 21' 50''	450.73 га
2	104° 3' 31.1''	44° 21' 50''	
3	104° 3' 31.1''	44° 22' 50''	
4	104° 5' 21.1''	44° 22' 50''	




Зураг 1-1. Төслийн талбайн байршил

1.2 Ил уурхайн ашиглалтын технологи, үндсэн хэмжээс

Ордын хүдрийн биетүүд нь газрын гадрагад ил гарштай, уртааш үргэлжлэн тогтсон, эдийн засгийн үр ашиг өндөр зэрэг уул техникийн нөхцөлд тулгуурлан ордыг ил аргаар авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан байна.

Хүснэгт 1-2. Уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Автотээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем	Хөрс хуулалт	<ul style="list-style-type: none"> – Өрөмдлөг тэсэлгээ – Ухаж ачих – Тээвэрлэх – Овоолох
	Хүдэр Олборлолт	<ul style="list-style-type: none"> – Өрөмдлөг тэсэлгээ – Ухаж ачих – Тээвэрлэх – Баяжуулах үйлдвэр



Зураг 1-2. Ил уурхайн 3D зураг

1.3 Орд ашиглалтын хугацаа ба төслийн хүчин чадал сонголт

Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллах ба ээлж солилцох хугацаа 2 цаг, бүтээлтэй ажиллах хугацаа 20 цаг байна. Уурхайн хүчин чадлыг оргил үедээ 690 мян.тн хүдэр олборлон уусган баяжуулахаар төсөлд тусгасан.

Хүснэгт 1-3. Уурхайн жилд ажиллах ажлын горим

Үзүүлэлт	Нэгж	Уурхай
Календарийн хоног	хоног	365
Ээлжийн тоо	тоо	2
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
Жилд сул зогсох өдөр	хоног	17
Үндэсний баяр, ёслол	хоног	15
Цаг агаарын хүндрэл	хоног	2
Өвлийн улирлын зогсолт	хоног	0
Уурхайн жилд ажиллах хоног	хоног	348
Уурхайн жилд ажиллах нийт цаг	цаг	8352

1.3.1 Тэсэлгээний ажил

Ордын тэсэлгээний ажил нь үндсэндээ андезит, брекчи зэрэг чулуулагт хийх тул чулуулгийн физик-механик шинж чанарт тулгуурлан үзүүлэлтүүдийг сонгож тооцоолсон. Ордын чулуулаг нь дунд тэслэгдэх зэрэглэлд багтдаг ба ашиглалтын үеийн хайгуулын үед ус бага илэрсэн. Иймд уулын цулыг Эмульсийн тэсрэх бодисоор тэслэхээр тооцов.

1.4 Уурхайн карьерт шүүрэх усны тооцоо

Ордын хайгуулын үе шатанд хийгдсэн судалгаанаас үзэхэд ордын талбайд ус бага <1 л/с илэрсэн. Харин борооны улмаас уурхайд ус хуримтлагдах учир зумпф-н аргаар

насосоор зайлуулахаар тооцсон. Усны насос нь Напор=170 м, Q=18-22 м³ байх бөгөөд 2 дамжлагаар газрын гадаргад шахна.

1.5 Баяжуулах технологийн сонголт, үндэслэл

Алтны үндсэн ордын хүдрээс алтыг ялган баяжуулах олон технологи байдгаас бага агуулгатай хүдрийн хувьд хамгийн түгээмэл ашиглагддаг технологи нь нуруулдан уусгах технологи болно. Цианид ашиглан алт уусгах арга нь түүний хямд үнэ болон алт, мөнгийг сонгомол хэлбэрээр уусгах чадварт үндэслэгдсэн. Харин агуулга өндөртэй алтны хүдрийг гравитаци-гангийн уусгалт хосолсон технологиор баяжуулвал илүү эдийн засгийн хувьд үр ашигтай байдаг.

“Бурхан дэл” алтны үндсэн ордын үйлдвэрлэлийн нөөц нь 1,455,246 тн хүдэр ба үүнээс Au>2 гр/тн агуулгатай хүдрийн хэмжээ 198,447.5 тн юм.

Иймээс технологийн туршилтын үр дүн болон төсөл захиалагч компаний санал болгосны дагуу Au>2 гр/тн агуулгатай хүдрийг гравитаци-гангийн уусгалт хосолсон, Au<2 гр/тн агуулгатай хүдрийг нуруулдан уусгахаар баяжуулах үйлдвэрийн төлөвлөлтийг боловсруулав.


Хэдийгээр цианид натрийн хору чанар нь анхаарал татах асуудал боловч уг урвалжийг технологийн горимын дагуу, зөв зохистой ашигласан тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөгүй, эрсдэл багатай байж болно. Энгийн цианидын давс буюу натрийн цианид нь усанд уусч диссоциацлагдан тухайн металлын давс, чөлөөт цианидын ионыг үүсгэдэг.




Цианжуулалтын үед алт нь хүчилтөрөгчөөр исэлдэж улмаар [Au(CN)₂]-гэсэн комплекс анионы байдлаар уусмалд шилжинэ. Энэ урвалыг дараах байдлаар илэрхийлнэ.



“Бурхан дэл” төслийн хувьд технологийн үндсэн урвал энэ болно.



Зураг 1-3. Баяжуулах үйлдвэрийн хүдэр бэлтгэх хэсгийн технологийн схем



Зураг 1-4. Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах технологийн схем

1.6 Ордын нуруулдан уусгах овоолго, хаягдлын сан

Тус алтны үндсэн ордын үйлдвэрийн нуруулдан овоолгын ажлын зураг төсөл нь Өмнөговь аймгийн ерөнхий архитектурын газар болон Барилга хот байгуулалтын яам, барилгын хөгжлийн төвөөр 2022 оны 12 сарын 13ны өдөр магадлал хийгдэж 2567/2022 дугаарт бүртгэгдсэн.

Техникийн шийдэл:

Нуруулдан уусгах талбай:

Нуруулдан уусгах байгууламжийн овоолгын талбай инженер геологоос харахад шимт болон элсэн хөрс маш нимгэн бөгөөд шууд хадан хөрс байна. Иймд газар шорооны ажил буюу ухлагыг бага байлгах зорилгоор шимт хөрсийг хуулж ухлагыг 20-60 см орчим ухаж талбайг тэгшиллээ. Овоолгын талбайн суурийн хөрс нь өгөршилд орсон хадан хөрс учир 30 см зузаантайгаар шавар хөрсийг жигд дэвсэн нягтруулж өгнө. Тус шавар үе нь доторлогоог цоорох болон шүүрэлтээс хамгаалах гэсэн давхар үүргийг гүйцэтгэнэ. Шавар үеийн дээр шингэний шүүрэлтээс хамгаалж 1.5 мм-ын зузаантай HDPE геомембраныг дэвсэж өгөхөөр зураг төсөлд тусгасан болно.

Нийт овоолгын талбайг тойруулан 1.5 м-н өндөр, 3.0 м хярын өргөнтэй, 1.5 налуутай шороон хамгаалалтын даланг нягтруулан хийж өгөхөөр төлөвлөсөн бай тус далагийн хяр дээл 0.8x0.8 м хэмжээтэй траншейд геомембран доторлогооны үзүүрийг хийж бэхлэхээр шийдлээ. Мөн дээр дурьдсаны дагуу овоолгын талбайг эхний болон дараагийн жилд гэж хуваасан ба хуваалтыг тусгаарлах даланаар хийж өгнө. Тусгаарлах далан нь 1.0 м-н өндөр, 1.0 м хярын өргөнтэй, 1.5 налуутай нягтруулсан шороо овоолгон далан байна.

Шүүрүүлэх хоолой:

Геомембранаар доторлож бэлдсэн овоолгын талбайд чиглүүлэх болон цуглуулах хоолойг хийж өгөхөөр зураг төсөлд орууллаа. Тус хоолойн дээд хэсэг буюу ханын 50 хувийг 15 см зайтайгаар зиг заг хэлбэртэй 10 мм голчтой нүхлэж бэлдсэн байна. Чиглүүлэх Ф110 мм болон цуглуулах Ф200 мм хоолойг давхар ханатай HDPE хоолойгоор хийнэ.

Дамжуулах хоолой:

Овоолгын талбайн баруун хойд хэсэг буюу хамгийн нам цэгт хамгаалалтийн далангийн доор уусмал дамжуулах хоолойг Ф300 мм-н HDPE хоолойгоор хийхээр төлөвлөв. Тус хоолойн нь уусмалыг овоолгын талбайгаа баян уусмалын санд дамжуулах үүргийг гүйцэтгэнэ. Дамжуулах хоолой нь газрын гадарга дээр ил байрлах ба хоолойд ямар нэг гэмтэл учирсан үед шингэнийг орчинд алдахгүй байх үүднээс Ф400 мм-ын голчтой HDPE хоолой дундуур явуулна. Мөн дамжуулах хоолойн эхлэл хэсэг буюу хамгаалалтын далангийн дотор хэсэгт хаалт Ф300 мм хаалтыг суурилуулж өгнө.

Хамгаалалтын хайрган үе:

Овоолгын талбайн геомембран доторлогоо дээр хамгаалалтын хайрган үеийг 30 см зузаантай гараар дэвсэж өгнө.

Хүдрийн овоолго:

180 мянган тонн буюу хүдрийн эзэлхүүн жинг 1.8 гр/см³ гэж тооцон нийт 80 мянган м³ хүдрийг эхний ба дараагийн жилд хуваан овоолохоор төлөвлөв. Хүдрийн овоолгын хормой нь бэлдсэн талбайд хамгаалалтын далангийн дотор хормойноос 5.0 м зайд m=1.5-н налуутайгаар 10.0 м өндөр тутамд мөн 5.0 м өргөнтэй дэвсэг гаргаж овоолохоор тусгалаа.

Баян уусмалын сан:

Баян уусмалын сан 12x20x4,0 м хэмжээтэй битүү хучилттай, төмөр бетон хийцтэй байна. Гэхдээ тус төмөр бетон санг хийхийн еөмнө 1.5 мм зузаантай HDPE геомембранаар ухлагын талбайг доторлож өгнө. Ингэснээр төмөр бетон сан шүүрэлт өгсөн тохиолдолд геомембран доторлогоо дээр тогтож байгальд уусмал алдахаас сэргийлэх болно. Баян уусмалын сангийн суурийн хэсэгт геомембран доторлогоо дээр суурийн цутгалт хийх учир

ул бетон геомембран доторлоогоо хоёрын завсар 400 гр/м² геотекстилийг дэвсэж өгнө. Төмөр бетон сангийн дотор талд шүүрэлтээс хамгаалах түрхлэгийг хийж өгнө.

Эрчимт уусмалын сан:

Эрчимт уусмалын сан нь нуруулдан уусгах овоолгын талбайд хур борооны ус буусан үеийн уусмалыг авах зорилготой бөгөөд 3.3-т тооцоонд дурьдсан зарцуулгыг багтаах буюу 12000 м³ багтаамжтай байна. Сангийн хийцийн хувьд хагас ухлага овоолгонд давхар HDPE 1,5 мм-н зузаантай геомембран доторлогоотой байх ба давхар геомембран хооронд 400 гр/м² геотекстилийг суурилуулсан байна. Геомембран болон геотекстил доторлогооны дээд үзүүрийг сангийн далангийн хярд 0.8x0.8 м хэмжээтэй траншейд хийж бэхлэнэ. Эрчимт уусмалын сангийн дотор налуу m=2.0, гадна налуу m=2.5, далангийн хярын өргөн 6.0 м байна. Мөн сангийн ёроолын зүүн хэсгийг дагсан 5.0 м өргөнтэй 1.0 м гүнтэй зумпыг хийнэ. Тус зумпны хэсэгт геомембран доторлогоо гэмтсэн эсэхийг мэдэх зорилгоор давхар геомембран дунд сангийн далангийн хяраас зумпны ёроол хүртэл Ф110 мм-н голчтой HDPE хоолойг суурилуулж өгнө.

Дамжуулах суваг:


Дамжуулах суваг нь нуруулдан овоолж уусгах талбайн баруун хойд хамгийн нам хэсэгт буюу хамгаалалтын даланг 0.5 м сэтлэж буюу халиагуур байдалтайгаар эхлэж эрчимт уусмалын санг хойд хэсгээр сангийн хярын түвшинээс 0.5 м доор холбогдох хүртэл үргэлжилнэ. Дамжуулах суваг нь байнгын ажиллагаатай биш учир HDPE 1.5 мм зузаантай дан геомембранаар доторлохоор шийдлээ. Тус сувгийн ёроол 2.0 м, гүн 0.5 м байна.

Шахах хоолой:

Баян уусмалын сангаас боловсруулах үйлдвэр, үйлдвэрээс овоолгын дээд хүртэл HDPE Ф250 мм-н хоолойг суурилуулна. Баян уусмалын сангаас боловсруулах үйлдвэр хүртлэх шахах хоолой нь аюулгүйн үүднээс давхар HDPE Ф350 мм хоолой дунд байрлана. Мөн үйлдвэрээс овоолгын талбай руу шахах хоолой нь хамгаалалтын даланг давтал HDPE Ф350 мм хоолой дунд байрлана.

Хувиарлах хоолой ба дулийн усалгаа систем:

Хүдрийн овоолгын дээр гол шахах HDPE Ф250 мм-н хоолой байрлах ба 12.0 м тутамд гол хоолойноос салбарлан хувиарлах HDPE Ф110 мм-н хоолойг ажлын зургийн хуудас-06. 13-г зурсний дагуу угсарч байрлуулна. Тус хувиарлах хоолой болгоны эхлэл хэсэгт хувиарлах хаалтыг хийхээр зураг тусгасан болно. Хувиарлах хоолойн 2 тал руу дараагийн хувиарлах хоолой хүртэл хоорондоо хамгийн ихдээ 0.80 м зайтай дуслын усалгааны хоолойг угсарч байрлуулахаар ажлын зурагт тусгаж өглөө. Дуслын усалгааны хоолойг угсарч байрлуулна.




Зураг 1-5. Нуруудан уусгах байгууламжийн ерөнхий план

1.7 Дэд бүтэц

Ил уурхайн цахилгаан хангамж- Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг дизель генератораас тэжээхээр тооцсон.

Ус хангамж- Технологийн хэрэгцээний усыг 14 км зайтай “Зээгт хотгор” газраас зөөж хангахаар төсөлд тусгасан байна. Ахуйн хэрэглээний усыг хангахаар талбай дээр 2 худаг гаргасан ба тус худгууд нь шаардлагатай тохилдолд баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээний тодорхой хэсгийг хангах юм. Технологийн ус хангамжийн авах байршлын зургыг доорх хэсэгт үзүүлэв.



Зураг 1-6. Зээгт хотгор уст цэгийн байршлын зураг
Хүснэгт 1-4 Технологийн хэрэгцээний шаардлагатай усны хангамж

Үзүүлэлт нэр	Хэмжих нэгж	Ашиглалтын жил		
		1-р жил	2-р жил	Нийт
СІС				
Уусгах хүдрийн хэмжээ	тн	653,276	603,522	1,256,798
Жилд уусгах хүдрийн талбай	м ²	57,488.2	53,109.9	110,598.2
		7	6	2
Технологид өгөх уусмалын хэмжээ	м ³ /цаг	100.00	100.00	100.00
Ууршилтаас алдагдах усны хэмжээ	м ³ /цаг	5.0	5.0	5.0
Технологид шаардлагатай усны хэмжээ	мян. м ³ /жил	827.83	764.78	1,592.61
	м ³ /цаг	5.00	5.00	5.00
Нэмж өгөх цэвэр усны хэмжээ	мян.м ³ /жил	100.50	83.91	184.41
	л/с	1.39	1.39	1.39
СІР				
Баяжуулах хүдрийн хэмжээ	тн	99,224	99,224	198,448
1 тн хүдэр баяжуулах усны зарцуулалт	м ³	3.00	3.00	3.00
Технологид орж байгаа усны хэмжээ	м ³ /цаг	36.0	36.0	36.0
Эргэлтийн ус	м ³ /цаг	33.84	33.84	33.84

Үзүүлэлт нэр	Хэмжих нэгж	Ашиглалтын жил		
		1-р жил	2-р жил	Нийт
Технологийн ус ашиглалтын коэффициент	%	94.00	94.00	94.00
Нэмж өгөх цэвэр усны хэмжээ	м ³ /цаг	2.16	2.16	2.16
	мян.м ³ /жил	17.86	17.86	35.72
	л	0.60	0.60	0.60
Нийт цэвэр усны зарцуулалт	м ³ /цаг	7.16	7.16	7.16
	мян.м ³ /жил	118.36	101.77	220.13
	л/с	1.99	1.99	1.99

1.7.1 Уурхайн унд ахуйн усны хэрэглээ

Бурхан дэлийн алтны үндсэн орд төслийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээг тооцоходоо БОНХАЖ-ын сайдын 2015.07.30 өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 12-р хавсралтад заасны дагуу тооцоог боловсруулав.

Уурхай хоногт 12 цагаар 2 ээлжийн горимоор жилд 328 хоног, баяжуулах үйлдвэр нь уурхайн ашиглалтын 2 дахь жилээс 12 цагаар 2 ээлжийн горимоор жилд 340 хоног ажиллах ба жилд 154-281 хүн ажиллана гэж тооцон усны хэрэглээг тооцоон доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1-5. Унд ахуйн усны хэрэглээ

№	Усны норм	Нэгж	Ашиглалтын жилүүд		
			1-р жил	2-р жил	3-р жил
1	50 литр	мян.м ³	2.3	4.3	4.6
5	Нийт хэрэгцээнд	мян.м ³	11.2		

“Мандал ресурс” ХХК нь уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээг уурхайн талбайд өрөмдсөн 2 хуггийн усаар хангахаар төлөвлөж байна.

1.7.2 Уурхайн зам усалгаа

Уурхайн дотоод тээврийн зам нь нийт 5.5 га талбайг хамарна. Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилтыг дарах зорилгоор усалгаа, чийгшүүлэлтийг ажлыг хийх ба зам усалгааг 7 хоногт 1 удаа хийнэ. Зам усалгааны тооцоог хийхдээ БОНХАЖ-ын сайдын 2015.07.30 өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралтад заасан Гудамж, зам, талбай услах нормыг ашиглан тооцоолов.

Хүснэгт 1-6. Уурхайн зам усалгааны усны зарцуулалт

№	Үзүүлэлтүүд	Талбайн хэмжээ	1м ² -д ноогдох усны норм	Усны зарцуулалт
1	Уурхайн зам	55000 м ²	2 литр	110000 литр буюу 110 м ³
	Нэг жилд			1760 м ³

Уурхайн зам усалгааг хийхэд 110 м³ ус зарцуулах бөгөөд дулааны улиралд зам усалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ. Дулааны улиралд усалгааг хийх ба 7 хоногт 1 удаа гэж тооцон 5-8 саруудад нийт 16 удаагийн усалгаа хийхээр байна. 1 жилд замын усалгаанд 1760 м³ ус зарцуулах тооцоолол гарч байна.

1.7.3 Ногоон байгууламжийн усалгаа

Ногоон байгууламжийн усалгааны тооцоог хийхдээ БОНХАЖ-ын сайдын 2015.07.30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралтад заасан *Цэцэрлэг, зүлэг, ногоо услах* нормыг ашиглан тооцоолов. Уурхайн эхний жилд ажилчдын тосгоны талбай болох 2.9 га талбайн 10% тай тэнцэх хэмжээний талбай буюу 2,9476 м² талбайд ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 1-7. Ногоон байгууламжийн усны зарцуулалт

№	Үзүүлэлтүүд	Талбайн хэмжээ	1м ² -д ноогдох усны норм	Усны зарцуулалт
1	Ажилчдын тосгоны ногоон байгууламж	2,9476 м ²	4 литр	11,790.4 литр
	Нэг жилд	188.8 м ³		

Ажилчдын тосгоны талбайн ногоон байгууламжийн усалгаанд 11,790.4 литр буюу 11.8 м³ ус зарцуулахаар байна. 7 хоногт 1 удаа усалгаа хийх ба 5-8 саруудад усалгааны ажлыг хийнэ. Нийт 16 удаагийн усалгааны ажлыг хийнэ гэж тооцвол 188.8 м³ усыг ногоон байгууламжийн усалгаанд зарцуулахаар тооцоолол гарлаа.

1.7.4 Нийт ус хэрэглээний тооцоо

Бурхан дэлийн алтны үндсэн орд нь ашиглалтын 3 жилд нийт 320.7 мян.м³ усыг ашиглах тооцоолол гарсан байна.

Хүснэгт 1-8. Усны хэрэглээний тооцоо

№	Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жилүүд		
			1-р жил	2-р жил	3-р жил
1	Ундны усны хэрэгцээ	мян.м ³	2.3	4.3	4.6
2	Уурхайн зам талбайн усалгаа	мян.м ³	1.8	1.8	1.8
3	Үйлдвэрийн хэрэглээ	мян.м ³	0	160.06	143.47
4	Ногоон байгууламжийн усалгаа	мян.м ³	0.2	0.2	0.2
5	Нийт хэрэгцээнд	мян.м³	4.3	166.36	150.07

Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээг хангахаар уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө талбайд 2 гүний худаг гарган хангахаар төлөвлөж байна.

1.7.5 Ажилчдын хотхон

Мандал ресурс ХХК нь ажилчдын хотхоныг нийт 3174.98м² талбайд төлөвлөсөн үүнээс барилгажих талбай нь 2545.1м² байна. Хотхон нь 4 блок 2давхар барилга болон зам, ногоон байгууламж амрах талбай. Үүнд:

- Зочид буудлын барилга-А блок

- Үйлчилгээний барилга- В блок
- Ажилчдын байр -С блок
- Гараж
- Дулааны зуухны байр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Цахилгааны дэд өртөө
- Харуулын байр
- Сагсан бөмбөгийн талбай
- Гар бөмбөгийн талбай



Зураг 1-7. Хотхоны ерөнхий төлөвлөлт

1.8 ХОГ ХАЯГДАЛ

Хатуу хог хаягдлын тооцоолол

Төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллахад нийт 281 хүн ажиллана гэж тооцвол: ахуйн гаралтай хатуу хог хаягдал (цаас, хоолны үлдэгдэл, лааз, шил г.м) хоногт дунджаар нэг хүн 0.5 кг буюу төслийн хугацаанд жилд нийт $348 \text{ хоног} * 0.5 \text{ кг} * 281 = 48.9 \text{ тн}$ хог хаягдал гарна.

Шингэн хаягдлын тооцоолол

Уурхайн ажиллагсад ахуйн хэрэглээ болон хооны газраас хаягдах ахуйн бохир шингэн хаягдал гарна. Нэг хүний усны хэрэглээний норм хоногт ажлын болоод ахуйн хэрэгцээнд дунджаар 125 литр байна гэж тооцвол 281 хүний унд ахуйн хэрэгцээнд хоногт нийт 35125 л ус хэрэглэхээр байна. Үүний 70 %-ийг ахуйн шингэн хаягдал болно гэж тооцвол хоногт дунджаар 24587.5.5 л шингэн хаягдал гарна гэж тооцож байна.

Ажилчдаас цаасан хаягдал, хуванцар савны хаягдал гарч болзошгүй юм. Ажилчдын оффис хэрэглээнээс гарах хог хаягдлыг 3 тасалгаат хогийн саванд түр цуглуулан сард 1 удаа өөрсдийн тээврийн хэрэгслээр Мандал-Овоо сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хаях нь зүйтэй юм.

Химийн бодисын сав, баглаа боодлын хаягдал: Бурхан дэлийн алтны үндсэн ордын Баяжуулах үйлдвэрээс химийн бодисын сав баглаа боодол, засвар үйлчилгээний газраас

шатах, тослох материалын сав баглаа боодол зэрэг хаягдлууд гарах боломжтой юм. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь аюултай хог хаягдлыг холбогдох дүрэм, журам, стандартын дагуу хадгалан, устгах шаардлагатай.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мандал ресурс ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй.

2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Мандал ресурс ХХК -ийн Бурхан дэлийн алтны үндсэн ордын олборлолтын ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох юм. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй байдаг тул бид 2023 онд ил уурхайн олборлолтын ажил эхлээгүй ч хүдэр баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж түүнтэй холбоотой БО-ны сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулж ажилласан талаар энэхүү биелэлтийн тайландаа тусгаж орууллаа.

Энэхүү төлөвлөгөөний биелэлтийг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг 1 жилээр тооцсоноос 2023 онд бодитоор зарцуулсан зардлыг тусгаж харууллаа.

2.1 Эрхзүйн үндэслэл ба гол шаардлага

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө,

зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулсан билээ.

Төслийг хэрэгжүүлэгч “Мандал ресурс” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ Мандал ресурс ХХК байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Төсөл хэрэгжүүлэгч “Мандал ресурс” ХХК тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй бөгөөд энэ үүргийн хүрээнд энэхүү биелэлтийн тайланг боловсрууллаа.

БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А-618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт боловсруулах аргачлал, зэргийг удирдлага болголоо.

2.2 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Бурхан дэлийн алтны үндсэн орд төслийн БОМТ-г Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба БОМТ-ний хүрээнд 2023 онд **80.8 сая төгрөг буюу наян сая найман зүүн мянган төгрөг** зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд ил уурхайн олборлолтын ажил эхлээгүй байгаатай холбоотойгоор техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажилд хийгдээгүй болно.

Хүснэгт 2-1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2023 онд нийт төлөвлөсөн зардал (сая төг)	2023 онд нийт зарцуулсан зардал (сая төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16.0 сая ₮	55.49 сая ₮
2	Нөхөн сэргээлт хаалтын менежментийн төлөвлөгөө	-	-
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих төлөвлөгөө	7.3 сая ₮	27.7 сая ₮
4	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	13.3 сая ₮	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14.5 сая ₮	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10.0 сая ₮	2.7 сая ₮
7	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	11.3 сая ₮	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	8.4 сая ₮	9.5 сая ₮
Нийт зардал		80.8 сая төгрөг	95.39 сая төгрөг

2.3 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан ба БОМТ-ний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг нэг жилээр боловсруулсан ба нийт 16.0 сая.төг буюу арван зургаан сая төгрөг зарцуулах тооцоолол гарсан байдаг ба бид бүтээн байгуулалтай холбоотой барилга байгууламж болон замтай холбоотой үүссэн тоосжилтоос хамаалах, агаарын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор усалгааг тогтмол хийсэн бол хөрсний бохирдолтийн сөрөг нөлөөллийг бууруулах, хянах зорилгоор

ажилчдын байр, хотхонд Газрын төлөв байдлын хянан баталгаа хийлгэн 40,000м² талбай бүхий газарт хөрс, ус, ургамлын төлөв байдлыг тодорхойлуулах ажил хийлгэсэн бөгөөд хотхон баригдаж дууссаны дараа 2023/12-р сард дараагийн Газрын төлөв байдлын хянан баталгаа хийлгэж “Газрын төлөв байдал, чанарт өөрчлөлт ороогүй, тохижилт сайтай” гэсэн дүгнэлт мэргэжлийн байгуулгаас гарсан болно. Мөн хүдэр баяжуулах үйлдвэрийн барилга /177,598м²/, Шохойн үйлдвэр /700м²/, Тэсрэх материалын агуулах /5,005м²/-ын газарт эхний байдлын Газрын төлөв байдлын хянан баталгаа хийлгэсэн бөгөөд дараа оны эхний улиралд тус бүтээн байгуулалт дууссаны дараа дахин газрын хянан баталгаажуулалт хийгдэхээр төлөвлөгдөөд явж байна. Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд хийгдсэн газрын хянан, баталгаажуулалт 9.5 сая төгрөг зарцуулсан бол зам усалгаа, агаарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 2023 онд нийт 54 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 2-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	2023 онд төлөвлөсөн зардал /сая.төг	Баримтлах стандарт, аргачлал	2023 онд зарцуулсан зардал /сая.төг
Агаарын чанар					MNS ISO4227-2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”	
Уурхайн олборлолт болон тээвэрлэлт, бутлуурын үед тоос босох	СНБАХ-ний бүлэгт тусгасан тоосжилт дарах дэвшилтэт арга технологиудыг судлан ашиглах	Олборлолт явуулах талбай болон тээвэрлэлтийн зам, бутлуурын талбай	Салхи ихээр босдог хавар, намрын улиралд 7 хоногт 1-2 удаа	3 сая ₮	MNS4585-2016, “Агаарын чанар.	
Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсч агаарын чанар	Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Олборлолт явуулах талбай болон тээвэрлэлтийн зам		1 сая ₮	MNS5885-2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.	1 сая ₮

MV-016759 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

сөргөөр нөлөөлөх	Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах	тээвэрлэлтийн зам		10 сая ₮	MNS6063-2010, “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”	53 сая ₮
хүнд даацын машин механизмаас гарах хорт хий агаарын чанарт сөргөөр нөлөөлж, агаарыг бохирдуулах	Стандарт шаардлагад нийцсэн тээврийн хэрэгслийг ашиглах, хяналт тавих	Хүнд даацын машин механизм	Жилд нэг удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах	MNS4990-2000, “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”	
Хаягдлын сан болон нуруулдан уусгах талбайгаас хийн ялгарал бий болох	Хаягдлын сан болон нуруулдан уусгах талбайн ойр орчимд агаар бохирдуулагч бодисуудын хэмжилт хийх	Хаягдлын сан Нуруулдан уусгах талбай	7 хоногт нэг удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Хорт утааны бохирдлын стандарт (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид	Ил уурхайн ажил эхэлж баяжуулах процесс эхлээгүй байгаа тул энэхүү ажил хийгдээгүй
Хөрсөн бүрхэвч						

<p>Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдож болзошгүй.</p>	<p>Асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах</p>	<p>Агуулах, засварын газар</p>	<p>Үйл ажиллагааны туршид</p>	<p>Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасгдан</p>	<p>MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм” MNS4919-2000, “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага” MNS5850-2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5914-2008, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт”</p>	<p>Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасгдан</p>
--	---	--------------------------------	-------------------------------	---	--	---

MV-016759 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

					MNS5915-2008, “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал”	
					MNS5917-2008, “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”	
Хаягдлын сангийн суурийн хэсэг цоорох элэгдсэн тохиолдолд уусмалын нэвчилт явагдан хөрсөн бүрхэвчийг бохирдуулна.	Хаягдлын сангийн зураг төслийн дагуу барьж, албан ёсоор ашиглалтад оруулах	Хаягдлын сан Нуруулдан уусгах талбай	2023	Үйл ажиллагааны зардалд тусгах	MNS5916-2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”	Үйл ажиллагаа эхлээгүй тул ажил хийгдээгүй
	Нуруулдан уусгах байгууламж болон хаягдлын сангийн нэвчилт явагдаж буй эсэхийг шалгаж хяналт мониторинг явуулах		7 хоногт нэг удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	MNS5918-2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”	Үйл ажиллагаа эхлээгүй тул ажил хийгдээгүй

МV-016759 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хог хаягдлаар бохирдох	Хогийн цэгийн орчин тойрны хөрсний бохирдлыг хянаж байх	Хогийн цэг		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан		2.7 сая ₮
Усан орчин						
Нуруулдан уусгах талбай болон хаягдлын сангаас шүүрэлт, нэвчилт үүсэх	Хаягдлын сан болон нуруулдан уусгах талбайгаас нэвчилт шүүрэлт үүсэж буй эсэхийг шалгаж, хянаж байх	Хаягдлын сан Нуруулдан уусгах талбай	7 хоногт нэг удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан		Үйл ажиллагаа эхлээгүй тул ажил хийгдээгүй
Уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорх усны хэт ашиглалтаас үүдэн тухай орчмын газрын доорх усны түвшин буурах	Худгуудыг тоолууржуулах	Худаг	2023	2 сая ₮		-
	Худгийн усны түвшин бууралтыг хянаж байх	Худаг	Жилд нэг удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан		-
ШТМ болон химийн бодисын асгаралт гүний усруу нэвчих	ШТМ болон химийн бодисын асгаралт бий болсон тохиолдолд хэрэглэх зүйлс болон арга хэмжээг дагаж мөрдөх	Төслийн талбай	Улиралд нэг удаа шалгаж, материалуудыг бэлтгэх	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан		-

MV-016759 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Унд ахуйн ус бохирдох	Унд ахуйд хэрэглэдэг усны эрүүл ахуйг хангаж хэрэглэх	Худаг	Жилд 2 удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав		1.45 сая ₮
Биологийн олон янз байдал						
Олборлолт болон тээвэрлэлт	Шимт хөрс хуулах талбайн ургамлан бүрхэвчийн мэдээллийг цуглуулах	Төслийн талбай	Жил бүрийн 5-6 сард	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	MNS5918-2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэрийн бүтээн байгуулалт явуулах хэсгийн шимт хөрсийг хуулж, тусгай газарт овоолго үүсгэсэн
Уурхай, НУБ болон хаягдлын санд мал амьтан орох	Ил уурхай, НУБ, хаягдлын сангийн хашааны бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, мал амьтан орохоос сэргийлэх	Төслийн талбай	Долоо хоног бүр	Дотоод зардалд тусгах	Байгаль орчны хамгаалах тухай хууль Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль Амьтны тухай хууль	Дотоод зардалд тусгагдсаны дагуу хашаа болон далан хамгаалах хүрээ хийгдсэн

MV-016759 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Уурхайн нөлөөллөөр биологийн олон янз байдал хомсдох	Уурхайн эргэн тойронд үзэгдсэн амьтдын зураг, ул мөр зэргийг тэмдэглэж авч амьтдын мэдээллийн сан үргэлжлүүлэх		2023	Дотоод зардлаар	Дотоод зардлаар
	Хавар намрын улиралд уурхайн орчмын амьтдад идэш тэжээл, ус зэргийг бэлдэж тавих		2023	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан
Хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаас болж амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхины ноёлох чиглэлийн дор байгуулж, хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх	Хогийн цэг	2023	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгах	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгах
Нийт зардал:				16.0 сая	55.49 сая ₮

Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах төслийн талбайд замын тэмдэг тэмдэглэгээ байршуулж буй фото зураг.







2.3.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Бурхан дэлийн алтны үндсэн орд нь ашиглалтын 3 дах жилээс ил уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлэх ба нөхөн сэргээлтийн ажлыг тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэх нь зүйтэй бөгөөд бид 2023 онд ил уурхайн ажил явагдаагүй тул нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй болно.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас өгсөн даалгаварын дагуу 2023 онд тусгай зөвшөөрлийн талбайд болон аймгийн зам дагуу 2000 ш мод тарихаар төлөвлөсөн боловч 2023 онд орон нутгийн удирдлага болон иргэд аж ахуйтай хэлэлцлийн дүнд “Амин хэлхээ байгаль сан” ТББ-тай гэрээ хийж эхний ээлжинд 450 ш модны суулгац худалдан авч тарихаар хүлээгдэж байгаа бол Мандал-Овоо сумын харьяат “Дээд гол” мод үржүүлгийн төрийн бус байгуулгатай 2300 ш модны суулгац авахаар гэрээ байгуулж 20 сая төгрөг өгсөн бөгөөд эдгээр модуудыг 2024 онд тарихаар төлөвлөгдөж байна.

Хүснэгт 2-3. Эхний жилийн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1-р жил	2023 онд хийгдсэн
Эвдрэлд орох талбай, га			
Ил уурхайн хэсэг	га	4.57	-
Хөрсний овоолго	га	6.88	-
Баяжуулах үйлдвэрийн талбай	га	8	8
Засварын цех, оффис	га	0.3	0.3
Ажилчдын хотхон	га	-	-
Тэсэлгээний агуулах	га	0.6	0.6
Зам болон бусад	га	5.5	5.5
Нийт эвдрэлд орох талбай	га	25.8	14.4
Шимт хөрс хуулах ажлын хэмжээ, м³			
Ил уурхайн хэсэг	м ³	9,133	-
Хөрсний овоолго	м ³	13,768	-
Баяжуулах үйлдвэрийн талбай	м ³	15,968	15,968
Засварын цех, оффис	м ³	514	514
Ажилчдын хотхон	м ³	-	-
Тэсэлгээний агуулах	м ³	1,166	1,166
Зам болон бусад	м ³	11,050	-
Нийт шимт хөрс	м³	51,599	17,648
Шимт хөрсөөр хучих нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, м³			
Ил уурхайн хэсэг	м ³		

МУ-016759 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бурхан дэлийн алтны үндсэн орд ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хөрсний овоолго	м3		
Баяжуулах үйлдвэрийн талбай	м3		
Засварын цех, оффис	м3		
Ажилчдын хотхон	м3		
Тэсэлгээний агуулах	м3		
Зам болон бусад	м3		
Нийт шимт хөрс	м3	-	-
Овоолго хэвгийжүүлэх ажил, м³			
Хөрсний овоолго	м3		
Биологийн нөхөн сэргээлтийн ажил, га			
Ил уурхайн хэсэг	га		
Хөрсний овоолго	га		
Баяжуулах үйлдвэрийн талбай	га		
Засварын цех, оффис	га		
Ажилчдын хотхон	га		
Тэсэлгээний агуулах	га		
Зам болон бусад	га		
Нийт биологийн нөхөн сэргээлт	га	-	-

Хүснэгт 2-4. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ

Байршил	2023 онд тарихаар төлөвлөсөн		2023 онд гүйцэтгэл		
	2024 онд тарихаар төлөвлөсөн модны хэмжээ, ш	Төлөвлөсөн зардал, сая.төг	Модны төрөл	Модны хэмжээ, ш	2024 онд зарцуулсан зардал, сая.төг
Тусгай зөвшөөрлийн талбайд	1000	3.65	Нарс	20	3.8891
Сумын төвд	0		Нарс	10	
Аймгийн зам дагуу	1000	3.65			
Мод үржүүлгийн газартай гэрээ хийж суулгац авах					23.825
Нийт дүн		7.3			27.7141

Хүснэгт 2-5. “Дээд гол” мод үржүүлгийн байгууллагуудтай хийсэн гэрээний хүрээнд авах модны хэмжээ, тоо ширхэг, мөнгөн дүн

№	Модны суулгацын нэр	Хэмжээ см	Нас	Тоо ширхэг	нэгж үнэ төг	нийт үнэ төгрөг
1	Хайлаас	40-60	2-3 настай	300	3500	1,050,000
2	Сухай	60-80	2-3 настай	300	7000	2,100,000
3	Заг	30-50	2 настай	200	15000	3,000,000
4	Тоорой	40-60	2-3 настай	100	15000	1,500,000
Нийт дүн				900		7,650,000

2.3.2 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ашигласнаар материаллаг болон эдийн засгийн шилжилт үүсдэг. Материаллаг шилжилт гэдэг нь айл өрх, тэдний өмч хөрөнгө (өвөлжөө, бууц, худаг), эзэмшлийг нүүлгэн шилжүүлэхийг хэлэх бөгөөд төслийн талбайгаас 500м дотор амьдардаг айл өрхүүдийг нүүлгэх үйл ажиллагаа юм. Эдийн засгийн шилжилт гэдэгт айл өрхүүд, тэдний мал сүрэг хуучин бэлчрээсээ, худаг уснаасаа алслагдаж нүүхийг хэлнэ. Төсөл хэрэгжүүлж буй талбайд айл өрх, тэдний эд хөрөнгө байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа явуулах шаардлагагүй тул энэхүү ажил хийгдээгүй болно.

2.3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгааллын хүрээнд 7 зүйлийн ховор ургамал (Шивлээхэй зээргэнэ, Хулан хойрго, Эгэл үмхий өвс, Потанины улаан тулам, Төв Азийн лавай, Шар шарилж, Монгол чоногоно), 4 зүйлийн хөхтөн амьтад (Аргаль, Янгир, Хар сүүлт, Цагаан зээр) хамгаалахаар сонгон авсан. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд доорх ажлуудыг хийхээр төлөвлөсөн ч бид энэхүү ажлыг үйл ажиллагаа бүрэн явагдаж эхлэх 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

- ✓ Сонгон авсан ургамлын зүйлүүдийг дүйцүүлэн хамгаалахаар сонгон авсан газар нутагт шилжүүлэн суулгах, үрийн генийн сантай болох, тарималжуулах туршилт үйлдвэрлэлийн ажлыг зохион байгуулах
- ✓ Амьтдын амьдрах таатай орчныг бий болгох: Зэрлэг амьтдад зориулсан автомат өргүүрт уст цэг байгуулах
- ✓ Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх (өвөл болон хаврын идэш тэжээл хомс үед зэрлэг амьтдад өвс, хужир тавих), зэрлэг амьтдын тогтмол ажиглагддаг, үржлийн үед чухал ач холбогдолтой газруудыг тэмдэгжүүлэх

- ✓ Хулгайн антай тэмцэх. Дүйцүүлэн хамгаалахаар сонгон зүйлүүд болон тэдгээрийн экологийн ач холбогдол, ирвэс идэш тэжээл хомсодсон үед л гэрийн мал руу дайрдаг талаар иргэд, малчид, уурхайн ажилчдад байгаль хамгаалах ТББ-уудтай хамтран сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх.



Уурхайн ажилчидын хотхон дээр тарьсан Нарс мод.

Хүснэгт 2-6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

ДХ газар	Үндэслэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж	2023 онд төлөвлөсөн зардал /сая.төг/	2023 онд зарцуулсан зардал /сая.төг/
	В	10-30	19.4	64.7	2.7	3	6.2	3.9	13.2

Энэ нэгж талбарт хээржүү цөлийн цайвар бор хөрс зонхилсон ба хөрсний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд тухайн нэгж талбарын хөрс нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний агрохимийн шинж чанар

Цэгийн дугаар	Давхарга	Гүн см	Ялзма г, %	рН	ИЛЧ, dsm	Давс, %	CaCO ₃ , %	Солилцох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca	Mg	K ₂ O	P ₂ O ₅
4609001751001001	А	0-10	0.30	8.2	0.05	0.03		5.7	3.6	9	1.5
	В	10-30	0.37	8.4	0.07	0.04		5.7	3.4	11	1.2

Нэгж талбарын хөрс нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн хэмжээ маш бага, хөдөлгөөнт фосфор Мачигины ангиллаар дунд хангамжтай, солилцох кали бага хангамжтай, солилцох суурийн нийлбэр 9.3 мг-экв/100гр хэмжээтэй хэлбэлзэж байна. Хялбар уусах давсны хэмжээ давсжилтгүй байгаа хөрсийг илтгэнэ.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Цэгийн дугаар	Давхарга	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын таньц	Перфингенсийн таньц
4609001751001001	Өгөгдөл хоосон байна			

Газар ашиглалт явагдаагүй тул хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийгдээгүй болно.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж /үндсэн/

Цэгийн дугаар	Давхарга	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Pb /Хар тугалга/	Cd /Кадьми/	Zn /Цайр/	Cu /Зэс/	Ni /Никель/	Cr /Хром/
4609001751001001	А	6.8		67.8	16.3	3.6	17.3

Судалгааны талбайгаас авсан өнгөн хөрсний дээжид өргөн тархалттай (Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu) хүнд элементийн агууламжийг тодорхойлууллаа. Задлан шинжилгээний дүнгээс үзэхэд цайрын агууламж нь Монгол улсын стандарт MNS 5850:2019-д заасан агууламжаас хэтрээгүй байна. Энэ нь тухайн хөрс нь хүнд металлын бохирдолгүйг илтгэнэ.

15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтолын зэрэглэл

Төслийн талбай нь уулын хөндийд байрлах бөгөөд Гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн ангийн дэгнүүлт үетэнт бүлгийн хазаар өвс-таана-жигиг алаг өвст зонхилон тархсан байна. Тус судалгааны талбайн хээрийн судалгааны үе шат гүйцэтгэсэн хугацаанд ургамал хагдралтын үедээ явж байсан бөгөөд монгол өвс-таана-бударганат бүлгэмдэлд зүйлийн бүрэлдэхүүний тоо 10м2 талбайд 6, ургамлын бүрхэц нь 25 %, халцгай газрын хэмжээ 10%, хад чулууны хэмжээ 70% га-гийн ургац 1.1 цн байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Цэгийн дугаар	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц % /1 м2/	Ургамлын бүрхэц % /100 м2 талбайд/	Зүйлийн бүрэлдэхүүний тоо /1 м2 талбайд/	Зүйлийн бүрэлдэхүүний тоо /100 м2 талбайд/	Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, Чулууны хэмжээ, %	1 га-н Ургац ц/га
4609001751001001	25	25	3	4		10	70	1.1

16. Усны чанар, төлөв байдал

16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:

Газар ашиглалтын аюулгүй байдлын хувьд нэгж талбар түүний ойр орчимд хүний үйл ажиллагаа болон байгалийн нөхцөлөөр үүссэн гуу жалга, нүх байхгүй. Орц гарцын байдал, өндөр хүчдэл, гал түймэр, үер ус зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй. Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай байхгүй байна.

17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж

- Нэгж талбарын хөрс авто машин, хүний үйл ажиллагаанаас болж хөрсөн зам үүссэн бөгөөд эзэмшиж буй талбайг хашаалж тэмдэгтжүүлэн байнгын ашиглагдах замыг хатуу хучилттай болгох шаардлагатай;
- Үйл ажиллагаатай холбоотойгоор гарцаагүй шаардлагатайгаас бусад нөхцөлөөр газар, хөрсийг эвдрэлд оруулахгүй байх, эвдрэлд орох газрын хэмжээг хамгийн бага байлгах удирдлага зохион байгуулалт, техник технологийн арга хэмжээг байнга авч байх;
- Автомашины дотоод, гадаад замын сүлжээг байгуулж, ашиглалтад нь хяналт тавих, холбогдох автозамын тэмдгүүдийг шаардлагатай газруудад стандартын дагуу хийж байрлуулах, төслийн талбайн хил зааг ба замаас гарч хөрсөн дээгүүр зам мөр гаргахгүй байх, замыг арчлах;
- Барилга байгууламж барих болон газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хурдас чулуулгийг тус тусад нь овоолго хийж, барилгын материалын хог хаягдлыг тусад нь байгуулсан зориулалтын талбайд зайлуулах;
- Хөрс хадгалах зориулалттай агуулах талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэлд орох нөхцөлийг хамгийн бага байлгахгаар төлөвлөх. Хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэхийн тулд сөрөг нөлөөлөлд өртсөн хөрсийг тухай бүр сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авч байх;
- Ургамал нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд барилгын ажил болон шинээр шугам сүлжээ, зам тавих ажлын үед барилгын материал түүхий эдийг тусгай бэлдсэн талбайд хураах, олон салаа зам гаргахгүй байх, нэгдсэн хогийн цэг байгуулж, уг хогийн цэгээс хог хаягдал орчиндоо тархахгүй байх арга хэмжээ авах нь зүйтэй.
- Барилгын ажилд эвдэгдсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу хийх;
- Төслийг хэрэгжүүлэх орчны ургамлын төрөл зүйл, тархалт, өсөлт хөгжилтөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
- “Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль болон бусад холбогдох дүрэм журам заасны дагуу уурхайн талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрс хамгаалах, нөхөн сэргээх арга ажиллагааг авч хэрэгжүүлэх, ялангуяа тус хуулийн 7.2.4-т явдсан зээмшил талбайн 10%-иас багагүй талбайд ногоон ургамал, мод тариалах;

БАТАЛГААЖСАН.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР //

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат хянан баталгаа

Огноо: 2022-08-22

1. Газар ашиглагч: "Бурхан дэл алт" ХХК
2. Аймаг (нийслэл): Өмнөговь Сум (дүүрэг): Мандал-Овоо
3. Байршил, хаяг: Өмнөговь аймаг, Мандал-Овоо сум, 2-р баг Хоримт
4. Нэгж талбарын дугаар: 4609001752
5. Хөрсний нэр:
6. Ургамалжилт:
7. Нийт талбайн хэмжээ: 700 м²
8. Газар эзэмших зориулалт: Уурхайн газар
9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж
10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Өмнөговь аймаг /нийслэл/-ийн Мандал-Овоо сум/дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн 04616-А/74/2022 тоот захирамж
11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:
12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

Газар ашиглалтын байдал	Талбай	Эвдэрч бохирдсон талбай		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар	700	-	-	-
Нэгж талбарын талбай	700	-	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	700	-	-	-
Дутуу ашиглаж байгаа газар	-	-	-	-
Илүү ашиглаж байгаа газар	-	-	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай				
1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай				
Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй талбай	700			
2.Үйл ажиллагаанд өртсөн талбай				
Б.Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай				
1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай				

2.Үйл ажиллагаанд өртсөн талбай				
---------------------------------	--	--	--	--

13. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал

Уул уурхайн барилга байгууламжийн зориулалтаар ашиглаж буй тус талбайд одоогоор ашиглалт явуулаагүй. Газрын гадаргын төлөв байдал өөрчлөгдөөгүй, унаган төрхөө алдаагүй байна.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл

Хөрсний механик бүрэлдэхүүн

Цэгийн дугаар	Давхарга	Гүн см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	0.001-с бага	0.01-с бага
4609001752001001	А	0-10	17.5	65.1	6.0	2.2	2.2	7.1	11.5
	В		21.9	68.8	2.7	2.8	1.6	2.2	6.6

Энэ нэгж талбарт хээржүү цөлийн цайвар бор хөрс зонхилсон ба хөрсний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд тухайн нэгж талбарын хөрс нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний агрохимийн шинж чанар

Цэгийн дугаар	Давхарга	Гүн см	Яломо г, %	рН	ЦД'1, dsm	Диву, %	CaCo3, %	Солилцох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca	Мg	K2O	p2o5
4609001752001001	А	0-10	0.38	8.41	0.094	0.05		15.2	2.6	5	2.1
	В		0.34	8.42	0.049	0.02		10.2	5.6	6	1.9

Нэгж талбарын хөрс нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн хэмжээ маш бага, хөдөлгөөнт фосфор Мачигины ангиллаар дунд хангамжтай, солилцох кали маш бага хангамжтай, солилцох суурийн нийлбэр 17.8 мг-экв/100гр хэмжээтэй хэлбэлзэж байна. Хялбар уусах давсны хэмжээ давжилтгүй байгаа хөрсийг илтгэнэ.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Цэгийн дугаар	Давхарга	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын таньц	Перфингенсийн таньц
4609001752001001	Өгөгдөл хоосон байна			

Газар ашиглалт явагдаагүй тул хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийгдээгүй болно.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж /үндсэн/

Цэгийн дугаар	Давхарга	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Pb /Хар тугалга/	Cd /Кадьми/	Zn /Цайр/	Cu /Зэс/	Ni /Никель/	Cr /Хром/
4609001752001001	A	2		37.5	20.6	7.2	26.4

Судалгааны талбайгаас авсан өнгөн хөрсний дээжид өргөн тархалттай (Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu) хүнд элементийн агууламжийг тодорхойлууллаа. Задлан шинжилгээний дүнгээс үзэхэд цайрын агууламж нь Монгол улсын стандарт MNS 5850:2019-д заасан агууламжаас хэтрээгүй байна. Энэ нь тухайн хөрс нь хүнд металлын бохирдолгүйг илтгэнэ.

15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтолын зэрэглэл

Төслийн талбай нь уулын хөндийд байрлах бөгөөд Гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн ангийн дэгнүүлт үетэнт бүлгийн хазаар өвс-таана-жигиг алаг өвст зонхилон тархсан байна. Тус судалгааны талбайн хээрийн судалгааны үе шат гүйцэтгэсэн хугацаанд ургамал хагдралтын үедээ явж байсан бөгөөд монгол өвс-таана-бударганат бүлгэмдэлд зүйлийн бүрэлдэхүүний тоо 10м2 талбайд 6, ургамлын бүрхэц нь 25 %, халцгай газрын хэмжээ 10%, хад чулууны хэмжээ 70% га-гийн ургац 1.1 цн байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Цэгийн дугаар	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц % /1 м2/	Ургамлын бүрхэц % /100 м2 талбайд/	Зүйлийн бүрэлдэхүүний тоо /1 м2 талбайд/	Зүйлийн бүрэлдэхүүний тоо /100 м2 талбайд/	Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хомжгоо, %	Хад, Чулууны хэмжээ, %	1 га-н Ургац /ц/га
4609001752001001	25	25	3	4		10	70	1.1

16. Усны чанар, төлөв байдал

16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:

Газар ашиглалтын аюулгүй байдлын хувьд нэгж талбар түүний ойр орчимд хүний үйл ажиллагаа болон байгалийн нөхцөлөөр үүссэн гуу жалга, нүх байхгүй. Орц гарцын байдал, өндөр хүчдэл, гал түймэр, үер ус зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй. Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай байхгүй байна.

17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж

- Нэгж талбарын хөрс авто машин, хүний үйл ажиллагаанаас болж хөрсөн зам үүссэн бөгөөд эзэмшиж буй талбайг хашаалж тэмдэгтжүүлэн байнгын ашиглагдах замыг хатуу хучилттай болгох шаардлагатай;
- Үйл ажиллагаатай холбоотойгоор гарцаагүй шаардлагатайгаас бусад нөхцөлөөр газар, хөрсийг эвдрэлд оруулахгүй байх, эвдрэлд орох газрын хэмжээг хамгийн бага байлгах удирдлага зохион байгуулалт, техник технологийн арга хэмжээг байнга авч байх;
- Автомашины дотоод, гадаад замын сүлжээг байгуулж, ашиглалтад нь хяналт тавих, холбогдох автозамын тэмдгүүдийг шаардлагатай газруудад стандартын дагуу хийж байрлуулах, төслийн талбайн хил зааг ба замаас гарч хөрсөн дээгүүр зам мөр гаргахгүй байх, замыг арчлах;
- Барилга байгууламж барих болон газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хурдас чулуулгийг тус тусад нь овоолго хийж, барилгын материалын хог хаягдлыг тусад нь байгуулсан зориулалтын талбайд зайлуулах;
- Хөрс хадгалах зориулалттай агуулах талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэлд орох нөхцөлийг хамгийн бага байлгахгаар төлөвлөх. Хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэхийн тулд сөрөг нөлөөлөлд өртсөн хөрсийг тухай бүр сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авч байх;
- Ургамал нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд барилгын ажил болон шинээр шугам сүлжээ, зам тавих ажлын үед барилгын материал түүхий эдийг тусгай бэлдсэн талбайд хураах, олон салаа зам гаргахгүй байх, нэгдсэн хогийн цэг байгуулж, уг хогийн цэгээс хог хаягдал орчиндоо тархахгүй байх арга хэмжээ авах нь зүйтэй.
- Барилгын ажилд эвдэгдсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу хийх;
- Төслийг хэрэгжүүлэх орчны ургамлын төрөл зүйл, тархалт, өсөлт хөгжилтөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
- “Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль болон бусад холбогдох дүрэм журам заасны дагуу уурхайн талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрс хамгаалах, нөхөн сэргээх арга ажиллагааг авч хэрэгжүүлэх, ялангуяа тус хуулийн 7.2.4-т заасан эзэмшил талбайн 10% иао багагүй талбайд ногоон ургамал, мод тариалах;

БАТАЛГААЖСАН.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР //



Нэгж талбарын дугаар: 4609001752
Улсын бүртгэлийн дугаар: Э-1106000081
Гэрчилгээний дугаар: 0000094472

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 6 сарын 24 өдөр

№ 04616-2022/00034

Өмнөговь аймаг/хот Мандал-Овоо
сум/дүүрэг

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Өмнөговь аймаг /нийслэл/-ийн Мандал-Овоо дүүрэг /сум/-ын Засаг даргын 2022 оны 06 сарын 23 -ны өдрийн 04616-А/74/2022 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Өмнөговь аймаг/хотын Мандал-Овоо сум/дүүргийн Газрын албаны мэргэжилтэн Ёндонжамц овогтой Насан-Өлзий, газар эзэмшигчийг төлөөлж "Бурхан дэл алт" ХХК-ны Гүйцэтгэх захирал Гансүх овогтой Дашдэндэв нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ

700 м2

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт
Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж

Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ
700 м2

Газар эзэмших хугацаа
15 жил

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Гурав. Газар эзэмшигчийн эрх

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /*Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах*/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь

хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

- 4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
- 4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
- 4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ 5 жилд нэг удаа хийлгэнэ./;
- 4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
- 4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах
- 4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах
- 4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх
- 4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх
- 4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
- 4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх
- 4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах
- 4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
- 4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах
- 4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах
- 4.19. Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, нөлөөлөл байгууламжид төлөвлөлт, ашиглалттай хийх
- 4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

- 5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;
- 5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:
 - а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх
 - б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх
 - в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах
 - г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй; эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48-р зүйлд** заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: **Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.**

Жич: “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны оорчлолтоос тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээр хамлаар шалтгаан бийгүй байсныг ойлгоно.

“... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар эзэмшүүлэгч;

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум

Засаг даргын Тамгын газрын Нэг цэгийн үйлчилгээ

Утас: 88061972

Газар эзэмшигч: "Бурхан дэл алт" ХХК овогтой

Газрын байршил: **Өмнөговь Мандал-Овоо 2-р баг Баянхошуу баг Бурхан дэл, Хоримт**

Газар эзэмшигчийн хаяг: **Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо**

Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: /5699134/

Банк, дансны дугаар: ,

Харилцах утас:

Газар эзэмшигч "Бурхан дэл алт" ХХК нь гэрээний нөцөлийг Газрын нэгдмэл сангийн удирлагын цахим систем /www.egazar.gov.mn/-д цагт зөвшөөрч, баталгаажуулав.

Энэхүү гэрээний нэг хувийг 4609001752 дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.



"GREEN LAB" LLC

ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ



№ 22/3526

Монгол улс, Увснийбаяр, Чингэлтэй дүүрэг
улс 51000, Дэл. Кинггат суурь 10 дивар 02 тосго
Утас/Факс: 77802029, 95867313
E-mail: landowner@greenlab.mn

Дээж ирсэн огноо: 2022.08.11-16

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "Ворлд Говь Групп" ХХК

Холбоо барих дугаар: 99144044

Дээж авсан газар: Өмнөговь аймаг Мандал овоо сум Баянхошуу баг "Бурхан Дэл Алт" ХХК ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай


Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	22/4126	Бурхан дэл-2	0-10	11.1	-	3.5	13.7	48.4	18.4
2	22/4127	Бурхан дэл-3	0-10	3.6	-	6.8	16.3	67.8	17.3
3	22/4128	Бурхан дэл-4	0-10	7.2	-	2.0	20.6	37.5	26.4
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувиалан олшруулахыг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS ISO 11466:2007)

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН: Шинжээч:
Шинжээч:
Шинжээч:



Г. Гэрэлтуяа
С. Мягмардаш
М. Энхзаяа

ХЯНАСАН: Лабораторийн эрхлэгч Г.Ганчимэг /MS.c/



"GREEN LAB" LLC

ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг
 1-р хороо, Цэг Капитал, 6-р 10 дугаар 02 тоот
 Утас/Факс: 778-2101, 98807313
 E-mail: landowner@ngolab.com

№ 22/3525

Дээж ирсэн огноо: 2022.08.11-16

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "Ворлд Говь Групп" ХХК

Холбоо барих дугаар: 99144044

Дээж авсан газар: Өмнөговь аймаг Мандал овоо сум Баянхошуу баг "Бурхан Дэл Алт" ХХК ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	CO ₂ , %	Ялзмаг %	Шингээгдсэн суурьуд, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	22/4118	Бурхан дэл-1	0-10	8.00	0.02	0.039	0.00	0.24	14.8	12.0	2.8	1.5	8
2	22/4119		10-30	8.07	0.05	0.096	0.66	0.46	8.2	5.2	3.0	0.8	12
3	22/4120	Бурхан дэл-2	0-10	8.09	0.02	0.042	0.00	0.31	13.1	10.0	3.1	1.5	7
4	22/4121		10-30	8.19	0.03	0.053	0.82	0.32	9.9	7.7	2.2	0.8	10
5	22/4122	Бурхан дэл-3	0-10	8.29	0.03	0.053	0.66	0.30	9.3	5.7	3.6	1.5	9
6	22/4123		10-30	8.40	0.04	0.078	0.99	0.37	9.1	5.7	3.4	1.2	11
7	22/4124	Бурхан дэл-4	0-10	8.41	0.05	0.094	1.15	0.38	17.8	15.2	2.6	2.1	5
8	22/4125		10-30	8.42	0.02	0.049	1.32	0.34	15.8	10.2	5.6	1.9	6


Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	22/4118	Бурхан дэл-1	0-10	12.9	76.3	3.2	4.1	2.4	1.1	7.6
2	22/4119		10-30	48.9	40.8	3.9	3.1	1.7	1.6	6.3
3	22/4120	Бурхан дэл-2	0-10	20.2	72.2	1.1	3.2	2.1	1.1	6.5
4	22/4121		10-30	18.7	70.0	3.4	4.0	3.2	0.8	7.9
5	22/4122	Бурхан дэл-3	0-10	15.0	76.2	4.7	0.4	3.4	0.3	4.2
6	22/4123		10-30	19.4	64.7	2.7	3.0	6.2	3.9	13.2
7	22/4124	Бурхан дэл-4	0-10	17.5	65.1	6.0	2.2	2.2	7.1	11.5
8	22/4125		10-30	21.0	68.8	2.7	2.0	1.6	2.2	8.8

Жич: Шинжилгээний харнуу нь тэнхэн тухайн цэгийн дээжид хамаарах ба хувиан олшруулахыг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
 (MNS3310:1991, MNS 6824:2020 MNS ISO 11466:2007)

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН: Шинжээч:
 Шинжээч:
 Шинжээч:



Т. Гэрэлтуяа
 С. Мягмардаш
 М. Энхзаяа

ХЯНАСАН: Лабораторийн эрхлэгч Г.Ганчимэг /MS.c/




БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ

Дугаар: 2022/0029

“Монгол улсын Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулиудын холбогдох заалтыг үндэслэн “Ворлдгоби групп” ХХК /3626237/-д Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх хүрээнд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа ажлын төрлөөр мэргэжлийн байгууллагын эрх”-ийг 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 3 жилийн хугацаатай олгов.

Мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй.

САЙД



Б.МӨНХБААТАР

Улаанбаатар хот
2022 он

БАТАЛГААНЫ ХУУДАС

Энэ хадгаламжийн нэгжид (83) 83 хуудас + дотоод

товъёогны 2

хуудас бүгд 85

хуудас дугаарлав.

Алгассан дугаар -

Давхардсан дугаар -

A3, A2 хэмжээтэй хуудасны дугаар 4

Дугтуй наасан, үдсэн хуудасны дугаар -

Гэмтэлтэй, сэлбэн засагдсан хуудасны дугаар -

Баталгаа бичсэн:

Wan Saikhan

Уржсанхай

20²² оны 10 сарын 07 өдөр

**“БУРХАНДЭЛ АЛТ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИЖ БУЙ ТАЛБАЙН ГАЗРЫН ТӨЛӨВ, БАЙДАЛ
ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

ЗАХИАЛАГЧ: “БУРХАНДЭЛ АЛТ” ХХК

Хянан баталгаа гүйцэтгэсэн : “Ворлд Гоби групп” ХХК



Газар зохион байгуулагч

Хөрс судлаач

[Handwritten signature]
[Handwritten signature: Б. Ариунтуяа]
[Handwritten signature: Урансайхан]

Б. Марал

Г. Ариунтуяа

Ж. Урансайхан

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ	3
1.1 Захиалагч байгууллагын товч танилцуулга	3
1.2. Оршил	3
1.3. Үндэслэл.....	4
1.4. Ажлын зорилго, зорилт.....	6
1.5. Мэргэжилтэн, тэдний гүйцэтгэсэн үүрэг	7
1.6. Ашигласан багаж, техник хэрэгсэл.....	7
1.7. Ашигласан журам, заавар.....	7
ХОЁР. ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН АРГАЗҮЙ	8
2.1. Бэлтгэл ажлын үе шат	8
2.2. Хээрийн судалгааны ажлын үе шат	9
2.3. Хөрсний лабораторийн задлан шинжилгээний ажлын үе шат	10
2.4. Материал боловсруулалтын ажил	10
ГУРАВ. БАЙРШИЛ, ГАЗАРЗҮЙН ОНЦЛОГ, УУР АМЬСГАЛ.....	12
3.1. Газрын гадарга	12
3.2 Тухайн бүс нутгийн болон ордын геологийн тогтоц	16
3.3 Уур амьсгал.....	16
3.4 Гадаргын ус.....	19
ДӨРӨВ. ХӨРСНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАР, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ	19
4.1. Хөрсөн бүрхэвчийн онцлог, төлөв байдал, элэгдэл эвдрэл, бохирдол	19
4.1.1. Судалгааны талбай орчмын хөрсөн бүрхэвч, түүний шинж чанар	19
4.1.2. Хөрсний зүсэлт, морфологи шинж чанар	20
4.2 Ургамлан нөмрөг	26
ТАВ. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ	28
ЗУРГАА.ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН, НЭГЖ ТАЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ГАЗАРТ УЧРУУЛАХ ХОХИРЛЫН ТООЦОО.....	29
6.1 Нэгж талбарын сүлжээний зураглал	29
ДОЛОО. ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	32
7.1 Дүгнэлт	32
7.2 Газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зөвлөмж	33
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ, МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	34

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг.....	12
Зураг 2. Талбайн өндөржилтийн зураг	13
Зураг 3. Байр зүйн зураг.....	14
Зураг 4. Физик газарзүйг мужлалт.....	15
Зураг 5. Монгол орны уур амьсгалын мужлалын зураг.....	17
Зураг 6. Агаарын темпартатур	18
Зураг 7. Монгол орны голуудын ай сав /1 – Хойт мөсөн далайн ай сав, 2 – Номхон далайн ай сав, 3 – Төв азийн гадагш урсацгүй ай сав	19
Зураг 8. Талбайн хөрсний зураг.....	20
Зураг 9. Талбайн ургамапжилтын зураг	27
Зураг 10. Хянан баталгааны ажлын сүлжээний зураг	29

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Товч танилцуулга	3
Хүснэгт 2. Хөрсний лабораторийн задлан шинжилгээний аргууд.....	10
Хүснэгт 3. Судалгааны талбайн газарзүйн солбицол	14
Хүснэгт 4. Хөрсний хими шинж чанар	21
Хүснэгт 5. Хөрсний физик шинж чанар	21
Хүснэгт 6. Хөрсний хүнд металлын агууламж.....	22
Хүснэгт 7. Газар ашиглалтын байдал.....	288
Хүснэгт 8. Нэгж талбарын сүлжээний зураглалын давхаргын нэр, атрибут мэдээлэлд талбар (Field) үүсгэсэн байдал, тайлбар	29

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1 Захиалагч байгууллагын товч танилцуулга

Хүснэгт 1. Товч танилцуулга

Захиалагчийн үндсэн мэдээлэл	Оноосон нэр	“Бурхан дэл алт” ХХК
	Регистрийн дугаар	5699134
	Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 4-р хороолол Амарсанаа 40а 9
	Утасны дугаар	312721
	Үйп ажиппагааны үндсэн чиглэл	• Гадаад худалдаа
Захиалагчийн ашиглаж буй газрын мэдээлэл	Газар ашиглах, эзэмших шийдвэр	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Засаг даргын 2022 оны 06 сарын 23 А/74 дүгээр тоот шийдвэр
	Нэгж талбарын дугаар	4609001749 4609001750 4609001751 4609001752
	Талбайн хэмжээ	45000 м ² 177452 м ² 5001 м ² 700 м ²
	Ашиглах, эзэмших зориулалт	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж

1.2. Оршил

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа нь тухайн үйл ажиллагаанаас газар болон түүнээс үндэстэй байгаль орчны тэнцвэрт байдалд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг (салхины элэгдэл, усны эвдрэл, үржил шимийн доройтол, цөлжилт, агаар, ус, хөрсний бохирдол гэх мэт) тогтоож, газрын хянан баталгааны улсын сүлжээнд хамруулж, төлөв байдал, чанарын анхны өөрчлөлттэй нь харьцуулах замаар дүгнэлт гаргадаг газрын менежментийн арга юм.

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын заавар”-ыг үндэслэн Өмнөговь аймгийн Мандал-Овоо 2-р багийн нутагт орших “Бурхан дэл алт” ХХК-ийн уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар эзэмшиж буй талбайд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг газрын мэргэжлийн байгууллага “Ворлд Гоби групп” ХХК хийж гүйцэтгэв.

Энэхүү захиалгат ажил нь тухайн газарт үйл ажиллагаа явуулах хугацаанд хийгдэж буй анхны хянан баталгааны ажил бөгөөд захиалгат хянан баталгааны ажил нь Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан

хугацаанд давтан тодорхойлж, улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан өөрчлөлтийг тодорхойлох, дүгнэлт гаргах зорилготой байна.

Ажлын үр дүн болох хянан баталгааны ажлын тайлан, нэгж талбарын сүлжээний зураг, паспорт (дүгнэлт) зэрэг нь Газар зохион байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ГЗБГЗЗГ болон аймаг, нийслэл, дүүргийн газрын албаар баталгаажин, цаашид Газар зохион байгуулалтад мөрдөх эрх бүхий баримт бичиг болох юм.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан, нэгж талбарын дүгнэлтэд тусгасан зөвлөмж, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх болон хянан баталгааны ажлыг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлох үүргийг газар ашиглагч “Бурхан дэл алт” ХХК хүлээнэ.

1.3. Үндэслэл

Газрын сангийн төлөв байдлыг ажиглах, түүний өөрчлөлтийг цаг алдалгүй илрүүлэх, үнэлгээ өгөх сөрөг процессуудыг үр дагаврыг урьдчилан харж дүгнэх болон арилгах чиглэлээр хийгдэж байгаа төрийн хяналтын арга хэлбэр, газрын менежментийн нэг хэсэг нь газрын төлөв байдлын мониторинг юм.

Газрын тухай хуульд “Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахыг” газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа гэж тодорхойлжээ.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлаар аж ахуйн нэгжүүдийн ашиглаж, эзэмшиж байгаа газрыг ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч, газар ашиглалтын онцлог зэргээс хамааруулан тодорхой нэгж талбаруудад хувааж тухайн үеийн газрын төрх төлөв байдал, чанарыг газар ашиглалт, тэдгээрийн төрлөөс хамааруулан Монгол улсын “Газрын тухай” хуульд заасан үзүүлэлтүүдээр илэрхийлэн нэгж талбарын сүлжээний зурагт оруулж, хянан баталгааны тайлан, дүгнэлт гаргаж нэгж талбар бүрийн паспорт бичдэг. Ингэснээр тухайн эзэмшигч, ашиглагчийн эзэмшил, ашиглалтад байгаа газарт гарч буй өөрчлөлтийг тодорхойлсны үндсэн дээр байгаль орчны тэнцвэртэй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхэд төрийн зүгээс хяналт тавих хууль эрх зүйн орчин бүрдэх боломжтой болох юм.

Монгол улсын “Газрын тухай хууль”-ийн 6 дугаар бүлгийн 58 дугаар зүйлд Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтын бүх газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийж байхаар зааж өгсөн нь, газар өмчлөгч эзэмшигч ашиглагч нар тухайн эдэлбэр газраа цаашид зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг

хуулийн хүрээнд авч явуулах эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа явдал юм. Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 7-д “Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшилд олгож байгаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тухайн газар эзэмших гэрээний хавсралт болгоно” гэж тусгаснаас гадна тус хуулийн 6 дугаар бүлэгт газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараах шаардлагыг биелүүлнэ гэж заасан. Үүнд:

1. Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны үлмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;
 2. Ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, шинжилгээний ажил хийх болон бусад хэрэгцээнд зориулан ухаж ашигласнаас эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулж байх;
 3. Сорилт туршилтын ажил, ашигт малтмалын эрэл хайгуулын явцад газрын төрх байдлыг өөрчлөхөд хүрвэл түүнийг нөхөн сэргээх, засаж тохижуулах;
 4. Газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;
 5. Ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;
 6. Төрийн өмчийн болон бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байх арга хэмжээг байнга авах.
- Мөн “Газрын тухай” хуулийн 7 дугаар бүлгийн 58 дугаар зүйлд “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа”-г хэрхэн хийхтэй холбогдсон дараах ерөнхий зохицуулалтыг зааж өгсөн болно. Үүнд:

1. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж, улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахыг газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа гэнэ.
2. Тариалангийн газраас бусад ангиллын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг дараах үзүүлэлтээр гаргана.
 - Хөрсний үржил шимт үе давхаргын зузаан;
 - Хөрсний ялзмагийн агууламж;
 - Хөрсний бохирдолт, хордолт;
 - Газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт;
 - Ургамлын ургац, бүрхэвчийн өөрчлөлт;
 - Бэлчээр, хадлангийн талбайн ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт.